



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/102/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

## **Агуулга**

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуушмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/111  
танай -ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020366

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>26,861,083.00</u></b>	<b><u>30,627,763.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>26,861,083.00</b>	<b>30,627,763.00</b>
351	Түүхий эд материал	8,000.00	961,500.00
35130	Эм боох материал	8,000.00	961,500.00
354	Хангамжийн материал	26,853,083.00	29,666,263.00
35410	Бичиг хэргийн материал	280,810.00	421,090.00
35420	Аж ахуйн материал	1,219,750.00	918,750.00
35440	Түлш, шатах тослох материал	2,436,700.00	2,227,250.00
35450	Барилгын засварын материал	00.00	500,000.00
35460	Хүнсний материал	153,005.00	987,105.00
35470	Бусад хангамжийн материал	22,762,818.00	24,612,068.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>444,383,212.35</u></b>	<b><u>431,236,802.85</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>444,383,212.35</u></b>	<b><u>431,236,802.85</u></b>
392	Биет хөрөнгө	436,213,212.35	423,066,802.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	438,163,707.00	438,163,707.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(22,340,344.54)	(32,927,183.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,306,301.00	20,306,301.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,555,128.20)	(16,410,306.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,623,923.00	34,603,923.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,444,125.91)	(21,728,517.99)
39217	Ном	458,880.00	1,058,880.00
393	Биет бус хөрөнгө	8,170,000.00	8,170,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000.00)	(275,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,170,000.00	8,170,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>471,244,295.35</u></b>	<b><u>461,864,565.85</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>471,244,295.35</u></b>	<b><u>461,864,565.85</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>471,244,295.35</u></b>	<b><u>461,864,565.85</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,536,193.00	126,536,193.00
512	Хуримтлагдсан үр дүн	232,767,348.37	223,387,618.87
51210	Өмнөх үеийн үр дүн	244,116,805.25	232,767,348.37
51220	Тайлант үеийн үр дүн	(11,349,456.88)	(9,379,729.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,940,753.98	111,940,753.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>471,244,295.35</u></b>	<b><u>461,864,565.85</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>236,260,200.00</b>	<b>257,118,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,249,000.00</b>	<b>2,301,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,249,000.00</b>	<b>2,301,100.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,249,000.00	2,301,100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>231,011,200.00</b>	<b>254,817,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>212,185,800.00</b>	<b>216,714,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	212,185,800.00	216,714,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,586,200.00</b>	<b>23,268,800.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,586,200.00	23,268,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,239,200.00</b>	<b>14,834,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,239,200.00	14,834,200.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>247,609,656.88</b>	<b>266,498,429.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>247,609,656.88</b>	<b>266,498,429.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>204,484,989.35</b>	<b>204,353,312.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>142,729,052.95</b>	<b>147,050,657.64</b>
210101	Үндсэн цалин	104,490,664.71	104,435,623.00
210102	Нэмэгдэл	20,208,671.00	25,619,673.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,770,000.00	5,308,000.00
210104	Урамшуулал	14,259,717.24	11,687,361.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,541,900.52</b>	<b>19,583,779.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,279,583.63	13,710,123.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,584,671.56	1,485,962.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,439.14	1,192,130.25
210204	Ажилгүйдлийн даатгал	302,655.10	287,451.11
210205	Эрүүл мэндийн даатгал	3,025,551.09	2,908,111.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,743,469.00</b>	<b>11,624,496.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,505,169.00	3,090,346.00
210302	Түлш, халаалт	9,238,300.00	8,498,150.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	36,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,871,421.00</b>	<b>1,761,086.00</b>
210401	Бичиг хэрэг	48,780.00	222,640.00
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	159,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,600.00	89,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	300,000.00

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	356,350.00	954,446.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	35,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,250,691.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,657,455.00</b>	<b>7,292,304.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,400.00	173,904.00
210502	Хоол, хүнс	9,601,055.00	6,943,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,000.00	175,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>70,000.00</b>	<b>100,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	70,000.00	100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>332,000.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	332,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,039,690.88</b>	<b>16,940,989.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	608,000.00	834,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	340,910.00	379,970.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,090,780.88	15,726,409.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,124,667.53</b>	<b>62,145,116.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,586,200.00</b>	<b>23,268,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	14,108,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,200.00	9,160,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>99,731.00</b>	<b>2,758,654.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,731.00	2,758,654.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>38,438,736.53</b>	<b>36,117,662.99</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,438,736.53	36,117,662.99
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(11,349,456.88)</b>	<b>(9,379,729.50)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(11,349,456.88)</b>	<b>(9,379,729.50)</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,536,193.00	112,395,609.26	243,661,949.97	482,593,752.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	454,855.28	454,855.28
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,536,193.00	112,395,609.26	244,116,805.25	483,048,607.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(454,855.28)	0.00	(454,855.28)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(11,349,456.88)	(11,349,456.88)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,536,193.00	111,940,753.98	232,767,348.37	471,244,295.35
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	126,536,193.00	111,940,753.98	232,767,348.37	471,244,295.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,536,193.00	111,940,753.98	232,767,348.37	471,244,295.35
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(9,379,729.50)	(9,379,729.50)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	126,536,193.00	111,940,753.98	223,387,618.87	461,864,565.85

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>231,011,200.00</b>	<b>254,817,600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>231,011,200.00</b>	<b>254,817,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>212,185,800.00</b>	<b>216,714,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	212,185,800.00	216,714,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,586,200.00</b>	<b>23,268,800.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,586,200.00	23,268,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,239,200.00</b>	<b>14,834,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,239,200.00	14,834,200.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>231,011,200.00</b>	<b>254,217,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>231,011,200.00</b>	<b>254,217,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>187,886,532.47</b>	<b>192,072,483.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>142,729,052.95</b>	<b>147,050,657.64</b>
210101	Үндсэн цалин	104,490,664.71	104,435,623.00
210102	Нэмэгдэл	20,208,671.00	25,619,673.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,770,000.00	5,308,000.00
210104	Урамшуулал	14,259,717.24	11,687,361.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,541,900.52</b>	<b>19,583,779.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,279,583.63	13,710,123.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,584,671.56	1,485,962.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,439.14	1,192,130.25
210204	Ажилгүйдлийн даатгал	302,655.10	287,451.11
210205	Эрүүл мэндийн даатгал	3,025,551.09	2,908,111.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,639,469.00</b>	<b>11,575,546.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,505,169.00	3,090,346.00
210302	Түлш, халаалт	10,134,300.00	8,248,200.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	237,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>997,700.00</b>	<b>2,440,000.00</b>
210401	Бичиг хэрэг	80,000.00	227,500.00
210402	Тээвэр, шатахуун	160,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,600.00	89,500.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	33,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	652,100.00	1,590,000.00

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,608,410.00</b>	<b>9,322,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,000.00	45,000.00
210502	Хоол, хүнс	9,136,410.00	7,777,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>70,000.00</b>	<b>100,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	70,000.00	100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>720,000.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,080,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	608,000.00	950,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	472,000.00	550,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,124,667.53</b>	<b>62,145,116.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,586,200.00</b>	<b>23,268,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	14,108,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,200.00	9,160,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>99,731.00</b>	<b>2,758,654.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,731.00	2,758,654.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>38,438,736.53</b>	<b>36,117,662.99</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,438,736.53	36,117,662.99
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0.00</b>	<b>600,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>600,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>600,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>600,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	600,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>(600,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	231,548,800.00	192,672,483.01	38,876,316.99	83.21
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	231,548,800.00	192,672,483.01	38,876,316.99	83.21
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	231,548,800.00	192,672,483.01	38,876,316.99	83.21
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	169,945,200.00	147,050,657.64	22,894,542.36	86.53
210101	Үндсэн цалин	109,311,800.00	104,435,623.00	4,876,177.00	95.54
210102	Нэмэгдэл	38,006,200.00	25,619,673.64	12,386,526.36	67.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,160,000.00	5,308,000.00	852,000.00	86.17
210104	Урамшуулал	16,467,200.00	11,687,361.00	4,779,839.00	70.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,942,600.00	19,583,779.37	3,358,820.63	85.36
210201	Тэтгэврийн даатгал	16,144,800.00	13,710,123.83	2,434,676.17	84.92
210202	Тэтгэмжийн даатгал	1,699,400.00	1,485,962.72	213,437.28	87.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,359,600.00	1,192,130.25	167,469.75	87.68
210204	Ажилгүйдлийн даатгал	339,900.00	287,451.11	52,448.89	84.57
210205	Эрүүл мэндийн даатгал	3,398,900.00	2,908,111.46	490,788.54	85.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,334,200.00	11,575,546.00	2,758,654.00	80.75
210301	Гэрэл, цахилгаан	4,577,200.00	3,090,346.00	1,486,854.00	67.52
210302	Түлш, халаалт	9,520,000.00	8,248,200.00	1,271,800.00	86.64
210303	Цэвэр, бохир ус	237,000.00	237,000.00	00.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,040,000.00	3,040,000.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	227,500.00	-127,500.00	227.50
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	89,500.00	110,500.00	44.75
210404	Ном, хэвлэл	50,000.00	33,000.00	17,000.00	66.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,190,000.00	00.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,186,800.00	9,322,500.00	9,864,300.00	48.59
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	45,000.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	17,641,800.00	7,777,500.00	9,864,300.00	44.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	00.00	100.00

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	<b>Томилолт, зочны зардал</b>	100,000.00	100,000.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	100,000.00	00.00	100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1500000.00	1500000.00	00.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	950,000.00	950,000.00	00.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	550,000.00	00.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	231,548,800.00	192,672,483.01	38,876,316.99	83.21
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	216,714,600.00	180,596,937.01	36,117,662.99	83.33
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	216,714,600.00	180,596,937.01	36,117,662.99	83.33
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	14,834,200.00	12,075,546.00	2,758,654.00	81.40
132001	Орон нутгийн төсвөөс	14,834,200.00	12,075,546.00	2,758,654.00	81.40

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>23,268,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23,268,800.00</b>
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,268,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,268,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,108,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,160,100.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>23,268,800.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,268,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,268,800.00

### 3. Аудитын ТАЙЛАН

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдэж, 2,825.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 247,609.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,476.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,733.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

#### **Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 216,714.6 мянга, орон нутгийн төсвөөс 14,834.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 23,268.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 254,217.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### **Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 1,980.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 600.0 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 321.1 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 21,023.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 17,578.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### Авлага, өглөгийн талаар:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөггүй тайлагнагдсан.

#### Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 30,627.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 431,236.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	26,861.1	30,627.8	3,766.7
Үндсэн хөрөнгө	444,383.2	431,236.8	(13,146.4)
Нийт хөрөнгө	<b>471,244.3</b>	<b>461,864.6</b>	(9,379.7)
Засгийн газрын хувь оролцоо	471,244.3	461,864.6	(9,379.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<b>471,244.3</b>	<b>461,864.6</b>	(9,379.7)

Бараа материалын дансны үлдэгдэл 30,627.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,766. мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 431,236.8 мянган төгрөг болж, 13,146. мянган төгрөгөөр буурсан нь элэгдэл байгуулснаас голлон шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 461,864.6 мянган төгрөг болж, 9,379.7 2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 230,436.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 14,834.2 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 245,270.6 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 245,270.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Архуст сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны хуралдааны 13 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн тодотгол баталжээ. Үүнд: Орон нутгийн төсвөөс 14,834.2 мянга, Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг 216,714.6 мянга, нийт 231,548.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 216,714.6 мянган, орон нутгийн төсвөөс 14,834.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 192,672.5 мянган төгрөгийг зарцуулж, 38,876.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 192,672.5 мянган төгрөг буюу 83.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 23,268.8 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 14,108.7 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 9,160.1 мянга, нийт 23,268.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 701,980.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 3,349.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, алдаатай тайлагнасан, харилцагчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө ашиглагдаж байгаа, үндсэн хөрөнгийн тооллогын баримт байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 144 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн боловсролын ахмад удирдах ажилтны зөвлөлөөс 600.0 мянган төгрөгийн “Төв аймгийн гэгээрэл боловсролын түүх” номыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зайлшгүй шаардлагатай бус зардал гаргасан нь Төсвийн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 12,961.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 10,658.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 39,476.3 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 38,876.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 600.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчилд 7 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулга**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлгийн 38,876.3 мянган төгрөгийн тохируулга хийгээгүйг залруулга хийлгэв.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1.Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

###### 1.1.Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”, 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт”, 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-д заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2.Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлж байх

##### **2.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

###### 2.1 Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 34 нэр төрлийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 2.2 Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

### **3.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

#### **3.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн тооллогын баримт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Тохиолдсон байх”, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **3.2 Өгсөн зөвлөмж:**

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### **4. Өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой асуудал**

#### **4.1 Илрүүлэлт:**

Харилцагчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **4.2 Өгсөн зөвлөмж:**

Харилцагчидтай авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### **5.Бараа материал данстай холбоотой асуудал**

#### **5.1 Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.15-д “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **5.2 Өгсөн зөвлөмж:**

УСНББОУС-17 шалгуурт нийцсэн хөрөнгийг бүртгэх, холбогдох зөвшөөрлийг авч шийдвэрлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### **6.Зардлын данстай холбоотой асуудал**

**6.1.Илрүүлэлт:**

Төв аймгийн боловсролын ахмад удирдах ажилтны зөвлөлөөс “Төв аймгийн гэгээрэл боловсролын түүх” номыг 600.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**6.2. Зөвлөмж:**

Төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**7. Шилэн данстай холбоотой асуудал**

**7.1.Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**7.2.Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд, үнэ зөв, бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг	8	39,476.3	1	38,876.3					7	600.0
	ДҮН	8	39,476.3	1	38,876.3					7	600.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт:  
[www.audit.mn](http://www.audit.mn)